

ХАРИЛЦАА ХОЛБОО

Шуудан, холбоо, интернэтийн үйлчилгээний орлого 2015 онд 709.4 тэрбум төгрөг болж, өмнөх оныхоос 16.6 тэрбум төгрөгөөр буюу 2.3 хувиар бүүрчээ.

Нийт орлогын 74.9 хувь буюу 531.5 тэрбум төгрөгийг нийслэл хотын хүн амд үзүүлсэн үйлчилгээнээс бүрдүүлсэн байна.


2015 онд нийслэлийн хэмжээнд суурин телефон цэгийн тоо 232.3 мянга болж, өмнөх оныхтой харьцуулахад 20.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Мэдээлэл, холбооны салбарын үндсэн үзүүлэлт


	Хэмжих нэгж	2014 он	2015 он
Нийт орлого	сая төг	725995.8	709373.3
Үүнээс: хүн амаас	сая төг	526130.1	531487.7
Суурин телефон цэг	тоо	193590	232327
Үүнээс: айл өрхийн	тоо	162134	196516
Утасгүй телефон	тоо	890	545
Үүрэн телефон хэрэглэгч	мян.хүн	1772.2	1967.3
КаТВ-ийн хэрэглэгч	тоо	302439	323344

Нийт суурин телефон цэгийн 196.5 мянга нь буюу 84.6 хувийг айл өрх ашиглаж байна. Өрхийн суурин телефон цэгийн тоо 2014 оныхоос 21.2 хувиар өссөн нь гурвалсан үйлчилгээний суурин утасны үйлчилгээг хэрэглэгч өрхийн тоо өсөн нэмэгдэж байгаатай холбоотой.

Зураг 1. Суурин телефон цэгийн тоо



Зураг 2. Үүрэн холбооны хэрэглэгчийн тоо



2015 онд Монгол Улсын хэмжээнд давхардсан тоогоор нийт 3.6 сая орчим хүн үүрэн телефон хэрэглэж байгаагийн 55.2 хувь буюу 1.9 сая гаруй хэрэглэгч нь нийслэл хотод байна. Өмнөх оныхтой харьцуулахад үүрэн телефон хэрэглэгчдийн тоо нийслэлд 195.1 мянгаар нэмэгдсэн.

Үүрэн холбооны нийт хэрэглэгчдийн 326.6 мянга нь дараа төлбөрт үйлчилгээний, 1640.7 мянга нь урьдчилсан төлбөрт үйлчилгээний хэрэглэгчид байна. Хөдөлгөөнт утасгүй телефон буюу WLL үйлчилгээний хэрэглэгчдийн тоо 0.5 мянга болж 2014 оныхоос 38.8 буурсан нь F-zone үйлчилгээний хэрэглэгчдийг CDMA болон GSM системд шилжүүлэх зохицуулалтын арга хэмжээ хэрэгжүүлсэнээс шалтгаалсан байна. Нийслэлд 0.8 мянган хэрэглэгч сансарын холбоог эзэмшдэг байна.

Өргөн нэвтрүүлгийн шугамаар Монголын Үндэсний Олон Нийтийн Радио орон даяар нэвтрүүлгээ хүргэсэн хэвээр байна. Мөн түүнчлэн “Лавайн эгшиг” радио сүлжээ, “Шинэ

Монгол” радио үндэсний хэмжээнд нэвтрүүлэг цацаж байгаагийн зэрэгцээ бүсийн хэмжээнд буюу Улаанбаатар хотод төдийгүй зарим аймгийн төвүүдэд нэвтрүүлгээ хүргэдэг 3 радио нийслэлд үйл ажиллагаа явуулж байна¹.

2015 онд Их хотын FM 92.1, Мэдээллийн радио 88.8 шинээр нээгдэж, Улаанбаатар хотын хэмжээнд нэвтрүүлгээ цацдаг радиогийн тоо 25 болж өсчээ. Хэдийгээр тооны өсөлт гарсан ч радиогийн долоо хоногийн нэвтрүүлгийн дундаж цаг Улаанбаатарт 113 болж өмнөх оныхоос 13 цагаар буурсан байна. Зөвхөн Улаанбаатар хотын хэмжээнд нэвтрүүлгээ цацаж буй нийт радиогийн 19 нь хувийн, 2 нь олон нийтийн статустай, 16.0 хувь нь шашны болон төрийн бус байгууллагын харьяалал дор үйл ажиллагаагаа явуулдаг байна.

Хүснэгт 2. Радиогийн үндсэн үзүүлэлт

	Радио станцын тоо	Үүнээс: FM радио	7 хоногийн нэвтрүүлгийн цаг	Үүнээс:		
				МҮОН-ийн радио	Улаанбаатар радио	FM радио
2015 он	31	28	4312	119	-	3913
2014 он	29	26	4088	119	-	3689
2013 он	29	26	4154	119	-	3776
2012 он	29	25	4312	119	28	3955
2011 он	27	25	4070	119	24	3927
2010 он	27	25	3581	119	24	3438

Хүснэгт 3. Телевизийн үндсэн үзүүлэлт

	Телевизийн тоо, нэвтрүүлэг цацдаг хүрээгээр			7 хоногийн нэвтрүүлгийн дундаж цаг
	Улсын хэмжээнд	Улаанбаатарын хэмжээнд		
		телевиз	суваг	
2015 он	16	37	17	118.0
2014 он	16	36	18	121.5
2013 он	16	37	18	125.0
2012 он	15	25	14	117.9
2011 он	16	20	19	123.3
2010 он	14	16	10	115.4

Радио давтамж болон DDish тавган антен ашиглан 16 телевиз эфирээ үндэсний хэмжээнд цацаж байна. Үндэсний хэмжээнд нэвтрүүлгээ хүргэж буй эдгээр телевизүүдийн долоо хоногийн нэвтрүүлгийн дундаж цаг 128 болж, өмнөх оныхоос нэг цагаар нэмэгджээ. Үндэсний хэмжээнд нэвтрүүлгээ цацдаг Шинэ дэлхий телевиз VTV телевиз болон өөрчлөгдөв.

2015 онд Улаанбаатар хотын хэмжээнд нэвтрүүлгээ цацаж байсан 4KMG, Пласс телевиз үйл ажиллагаагаа зогсоож, Шууд, Смарт4К, Монголын мэдээ гэсэн 3 телевиз шинээр байгуулагдаж, нийтдээ 54 телевиз үйл ажиллагаа явуулсан бөгөөд долоо хоногийн эфирийн дундаж цаг нь 118 болж, өмнөх оныхоос 4-өөр нэмэгдсэн байна.

Веб сайтаар үзэх боломжтой сувгуудаас гадна www.tv.univision.mn-ийн IPTV үйлчилгээгээр 49 суваг, www.skymedia.mn-р 30 сувгийг онлайнаар үзэх боломжтой юм. Түүнчлэн “Mongol TV” гар утасны аппликейшнээр 10 суваг, “TV Guide Mongolia” гар утасны аппликейшнээр 6 суваг, “TV5 Cloud” аппликейшнээр TV5 телевизийн нэвтрүүлгийг үзэх боломжтой байна.

Бусад хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй харьцуулахад телевизүүд контентоо түгээхдээ цахим орчныг ашиглах нь нэмэгдэж байгаа юм. Хэвлэл мэдээлэл хэрэглэгчдийн судалгааны дүнгээс үзэхэд нийслэлчүүдийн телевиз үзэх хугацаа орон нутгийн иргэдтэй харьцуулахад бага, хамгийн ихдээ 2-3 цагийг зарцуулдаг бөгөөд спортын нэвтрүүлгийн илүүтэй үздэг ажээ.

¹ Хэвлэлийн Хүрээлэн, “Монголын хэвлэл мэдээлэл өнөөдөр” судалгааны тайлан, 2016 он

Хүснэгт 4. Нийслэлийн телевизортой өрх


Дүүрэг	Телевизортой өрх, бүгд				Үүнээс: Гэртээ нэг телевизортой өрх			
	2012 он	2013 он	2014 он	2015 он	2012 он	2013 он	2014 он	2015 он
Хан-Уул	33904	35207	39048	43182	29996	31190	34748	39985
Баянзүрх	74611	79525	85866	93055	63150	67700	73599	80658
Баянгол	49668	52386	55529	57844	35518	37843	40741	43091
Сүхбаатар	36012	36027	36056	37851	30519	30934	31915	34825
Чингэлтэй	37621	38820	39523	41407	32719	34788	35472	38153
Сонгинохайрхан	65002	70654	77093	82835	58824	63435	68336	75742
Налайх	8987	9156	9723	10044	8607	8763	9382	9696
Багануур	7814	7972	8162	8422	7254	7385	7686	8055
Багахангай	1000	1031	1076	1190	829	879	918	1155
Улаанбаатар	314619	330778	352076	375830	267416	282917	302797	331360

2015 онд нийслэлийн нийт өрхийн 99.8 хувь буюу 375.8 мянган өрх телевизортой байсан бөгөөд эдгээр өрхийн 88.2 хувь нь нэг телевизортой ажээ. Телевизортой өрхийн 30.0 хувь нь сууцны тусдаа байшинд, 41.5 хувь нь нийтийн зориулалттай орон сууцанд, 28.1 хувь буюу 105.7 мянган өрх нь монгол гэрт амьдарч байв.

Кабелийн телевизийн хэрэглэгчдийн тоо жил ирэх тутамд өсөн нэмэгдэж байна. Монгол Улсын хэмжээнд кабелийн телевизийн сувагт холбогдсон нийт хэрэглэгчдийн дийлэнх буюу 84.1 хувь нь нийслэл хотод ногдож байна. Улсын дүнд нийслэл хотын эзлэх хувийн жин 2014 онд 2013 оныхоос 1.6 пунктээр буурч байсан бол 2015 онд өмнөх оныхоос 1.4 пунктээр өссөн байна. 2015 онд нийслэлийн хэмжээнд кабелийн 18 телевизээр нийслэлийн 323.3 мянган хэрэглэгч үйлчлүүлсэний 95.0 хувийг айл өрх эзэлж байна.

Тогтмол үйл ажиллагаа явуулсан кабелийн телевизийн үйлчилгээ эрхлэгчдээс 16 нь нийслэлийн төвийн 6 дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж, хоногт дундажаар 50-130 гаруй сувгаар (хотын захын дүүрэгт 49-60 хүртэл) нэвтрүүлэг хүргэсэн байна.

Зураг 3. КаТВ-ийн сувагт холбогдсон хэрэглэгч



Хүснэгт 5. КаТВ-ийн хэрэглэгч

Он	Монгол Улс	УБ хот	Улсын дүнд УБ хотын эзлэх хувь
2015	384356	323344	84.1
2014	360923	298310	82.7
2013	277968	234456	84.3
2012	227045	192227	83.2
2011	180052	151077	83.9
2010	120551	95262	79.0

Гурвалсан үйлчилгээнээс бусад кабелийн телевизийн сувагт холбогдох шинэ тавилтын үнэ нийслэлийн төвийн 6 дүүргийн айл өрхөд 10.0-99.0 мянган төгрөгийн хооронд байхад үйлчилгээний төлбөрийн сарын хураамж өрхөд 4000-9900 төгрөгийн тарифтай байв.

Хүснэгт 6. Компьютертэй болон интернэтэд холбогдсон өрх

Дүүрэг	Компьютертэй өрх, бүгд				Үүнээс: Интернэтэд холбогдсон өрх			
	2012 он	2013 он	2014 он	2015 он	2012 он	2013 он	2014 он	2015 он
Хан-Уул	13138	14785	19003	24031	6121	6576	11127	19489
Баянзүрх	36147	39853	43115	46770	22162	24835	27198	30133
Баянгол	33156	38425	39293	42945	23111	30112	31875	36919
Сүхбаатар	19025	19894	21955	19584	11580	13372	15425	15587
Чингэлтэй	11211	14462	14640	14951	4312	6565	6584	6830
Сонгинохайрхан	18491	23976	28128	30386	8045	11553	15542	19811
Налайх	2263	2764	3314	3288	712	1012	2004	2353
Багануур	1964	2346	2370	3174	495	666	1343	2617
Багахангай	217	256	267	383	43	104	170	224
Улаанбаатар	135612	156761	172085	185512	76581	94795	111268	133963

2015 онд нийслэлийн нийт өрхийн 49.3 хувь нь буюу 185.5 мянган өрх гэртээ компьютертэй байв. Эдгээр өрхийн 63.1 хувь буюу 117.0 мянга нь нийтийн зориулалттай орон сууцанд, 13.0 хувь буюу 24.0 мянган өрх нь монгол гэрт амьдардаг байна.

Нийслэлийн нийт өрхийн 35.6 хувь, гэртээ компьютертэй өрхийн 72.2 хувь буюу 133.9 мянга гаруй өрх интернэтэд холбогджээ. Интернэтэд холбогдсон нийт өрхийн 75.9 хувийг нийтийн зориулалттай орон сууцанд амьдардаг өрх, 16.7 хувийг сууцны тусдаа байшинд амьдардаг өрх эзэлж байна.

Зураг 4. Интернэтэд холбогдсон өрх, сууцны төрлөөр, 2015 он

